1

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 01 сарын 17 өдөр Дугаар 24 (01) Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн
З.Нарантуяа -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр Монголбанк, Сангийн яам, холбогдох бусад яам, агентлаг, байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Я.Содбаатар/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 01 сарын 17 өдөр Дугаар 25 (02) Улаанбаатар хот

**Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргыг сонгох тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.9, 24.10 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Монгол Улсын Их Хурлын Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарыг улируулан сонгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

VXA0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 04 сарын 11 өдөр Дугаар 03 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь хэсэг, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны 2017 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооноос гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

Ч.Цэвэгдорж -Үндэсний статистикийн хорооны Тамгын газрын дарга

Л.Батмөнх -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх

Г.Баярмаа -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт

Б.Нандингэрэл -УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн референт

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 04 сарын 11 өдөр Дугаар 04 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь хэсэг, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хороогоор хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооноос гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Х.Болорчулуун -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн
З.Нарантуяа -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

Т.Жамбаажамц -Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга

С.Энхцэцэг -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх

Г.Баярмаа -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт

Б.Нандингэрэл -УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн референт

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

5

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 04 сарын 11 өдөр Дугаар 05 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5, 19.2.8 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 46 дугаар зүйлд заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл болон Улсын Их Хурлаас гаргах шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

| | |
|---|---|
| Б.Дэлгэрсайхан | -Улсын Их Хурлын гишүүн |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| Л.Болд | -Улсын Их Хурлын гишүүн |
| М.Оюунчимэг | -Улсын Их Хурлын гишүүн |
| Я.Содбаатар | -Улсын Их Хурлын гишүүн |
| Д.Тэрбишдагва | -Улсын Их Хурлын гишүүн |

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг / Б.Дэлгэрсайхан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

Батлав: УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ Б.ДЭЛГЭРСАЙХАН

Нэг. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг хэлэлцүүлэгт бэлтгэх, үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх багийн бүрэлдэхүүн:

| | |
|---|---|
| Д.Хүрэлбаатар | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| Б.Лхагвасүрэн | Монголбанкны Дэд ерөнхийлөгч |
| У.Бямбасүрэн | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга |
| Б.Баярсайхан | Санхүүгийн зохицуулах хорооны дэд дарга |
| Ж. Бат-Эрдэнэ | ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| С.Магнайсүрэн | БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| Г.Нандинжаргал | УУХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| З.Мэндсайхан | ЭХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга |
| Б.Баярсайхан | Үндэсний хөгжлийн газрын дарга |
| М.Даваанyam | АЕГ-ын гүйцэтгэлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор |
| Г. Батхүрэл | СЯ-ны Эдийн засгийн бодлогын газрын дарга |
| Э.Бат-Идэр | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга |
| Д.Мягмарцэрэн | Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх |
| Г.Баярмаа | Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт |
| Д.Хосбаяр | УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн референт |

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ АЖЛЫН АЛБА

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
# БАЙНГЫН ХОРООНЫ
# ТОГТООЛ

2018 оны 04 сарын 18 өдөр Дугаар 06 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Эрдэнэс Таван толгой” ХК-ийн хувьцааг хөрөнгийн зах зээлд бүртгүүлэх, арилжих, эргэлтэд оруулах замаар иргэдэд эзэмшүүлсэн 1072 ширхэг хувьцааг үнэ цэнэтэй болгох талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх, Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

| | |
|---|---|
| Л.Энх-Амгалан | -Улсын Их Хурлын гишүүн |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| Ж.Ганбаатар | -Улсын Их Хурлын гишүүн |
| З.Нарантуяа | -Улсын Их Хурлын гишүүн |
| Я.Содбаатар | -Улсын Их Хурлын гишүүн |
| Д.Тэрбишдагва | -Улсын Их Хурлын гишүүн |

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

| | |
|---|---|
| С.Наранцогт | -Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Г.Нандинжаргал | -Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| С.Даваасүрэн | -Санхүүгийн зохицуулах хорооны дарга |
| Х.Алтай | -Монголын Хөрөнгийн биржийн захирал |
| Ш.Лхагва | -“Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-ийн гүйцэтгэх захирал |
| Б.Ганхуяг | -“Эрдэнэс-Таван толгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч |
| Ц.Түмэнцогт | -“Эрдэнэс-Монгол” ХХК-ийн гүйцэтгэх захирал |

| | |
|---|---|
| Г.Ганболд | -“Эрдэнэс-Монгол” ХХК-ийн Санхүү эрхэлсэн дэд захирал |
| С.Энхцэцэг | -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх |
| Б.Ууганцэцэг | -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны референт |

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 04 сарын 18 өдөр Дугаар 07 Улаанбаатар хот

**Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2017 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 22 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд чиглэл болгосугай:

1/Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дэлгэрэнгүй төлөвлөгөөг боловсруулж, биелэлтийг хангах;

2/хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх цогц арга хэмжээний хүрээнд хөрөнгө оруулалтын банк, сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани зэрэг институцийн хөгжлийг дэмжих, хөрөнгийн захад банкны зээлээс бусад санхүүжилтийн хэлбэрийг бий болгох, тэтгэврийн сангийн шинэчлэл хийх;

3/инфляцийн түвшинг нэг оронтой тоонд барихад чиглэсэн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх;

4/банк болон зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс бусад этгээдийн богино хугацаанд хэт өндөр ашиг олох зорилготой, мөнгө угаалтын шинж агуулсан зээл, зээллэг, өрийн хүү тооцох харилцааг хязгаарлаж, шаардлагатай тохиолдолд хүү, хүүлэлтийн дээд хязгаарыг тогтоож, хяналт тавих;

5/Ипотекийн зээлийн хөтөлбөрийг тогтвортой, зохистой хэмжээнд хадгалж, зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх;

6/Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах;

7/гадаад эдийн засгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, тэдгээрийн хүртээмжийг нэмэгдүүлэх;

8/иргэдийн санхүүгийн боловсролыг сайжруулах, тэдний хуримтлал үүсгэх идэвх, хандлагыг нэмэгдүүлэх, харилцагчдын эрх ашгийг хамгаалах.

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай:

1/эдийн засгийн суурь үзүүлэлтийг сайжруулах, эдийн засгийг тэлэх, төрөлжүүлэх, иргэдийн орлого, баталгаат ажлын байрыг нэмэгдүүлэх, урт хугацаанд эдийн засгийг тогтворжуулах, гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээх, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, төлбөрийн тэнцлийг сайжруулах, томоохон төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх;

2/жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр тогтвортой санхүүжилтийн сан, бусад санхүүгийн дэд бүтэц, эх үүсвэрийг бүрдүүлэх хүрээнд олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах;

3/эдийн засаг, бизнес, санхүүгийн салбар дахь төрийн дарамт, хүнд суртлыг арилгах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шуурхай болгох;

4/банкны мөнгөн хадгаламжийн хүүгийн орлогод ногдуулах албан татварын хувь хэмжээг хадгаламжийн хэмжээнээс хамаарч шатлалтай тогтоох асуудлыг судлах.

3.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосугай:

1/Зээлийн хүүг бууруулах стратегийг 2018 оны эхний хагаст багтаан баталж, Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулах;

2/үнийн тогтвортой байдлыг хангах замаар инфляцийн дарамтгүй эдийн засгийн өсөлтийг дэмжих мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх;

3/дотоодын мөнгөний зах зээл дэх хадгаламжийн долларжилтыг бууруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, үндэсний мөнгөн тэмдэгтэд итгэх итгэлийг сэргээх;

4/банкны заавал байлгах нөөц, өөрийн хөрөнгийн хэмжээ, хөрвөх чадварын харьцаа зэрэг үзүүлэлтэд тавигдах шаардлагыг уян хатан зохицуулах замаар мөнгөний зах зээл дэх сул чөлөөтэй эх үүсвэрийн ашиглалтыг сайжруулах;

5/банкны хадгаламжийн хүүг өрсөлдөөний зорилгоор дундаж хүүгээс хэт өсгөж тогтоосон тохиолдолд хадгаламжийн даатгалын өндөр шимтгэл болон Монголбанкнаас тогтоосон банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт зэрэг арга хэрэгслийг ашиглан бууруулах арга хэмжээг авч байх;

6/Зээлийн мэдээллийн сангийн тухай хуулийн хэрэгжилтийг идэвхжүүлж, зээлийн үнэлгээний системд яаралтай шилжих, зээлийн үйл ажиллагааны зардлыг бууруулах, зээлийн мэдээллийн бүрдүүлэлт, боловсруулалтыг сайжруулах, зээлийн мэдээллийн үйл ажиллагаанд хувийн секторын оролцоог хангах замаар зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн тоог нэмэгдүүлэх;

7/хэрэглэгчийг хамгаалах хууль, эрх зүйн орчин, хяналт, зохицуулалтыг сайжруулах.

4.Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх чиглэлийн төслийг санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын санд зөвшөөрөл өгөх, бүртгэх асуудлыг

цаг алдалгүй шийдвэрлэж, зохих дэмжлэг үзүүлж ажиллахыг Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд чиглэл болгосугай.

5.Тогтоолын хэрэгжилтийг жил бүрийн 6, 12 дугаар сард тус тус багтаан Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байхыг Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 04 сарын 25 өдөр Дугаар 08 Улаанбаатар хот

**Чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний статистикийн хорооны бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх, төсөв, санхүүжилтийн хүрэлцээг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах чиглэлээр идэвхтэй дэмжлэг үзүүлэхтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд чиглэл болгосугай:

1/Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу төрийн захиргааны төв байгууллагын бүтцэд салбарын статистикийн үйл ажиллагаа эрхлэн гүйцэтгэх нэгж байгуулах асуудлыг шуурхай шийдвэрлэх;

2/албан ёсны статистикийн тогтолцоог анхан шатны нэгжид бэхжүүлэх, эдийн засаг, нийгмийн суурь судалгааны үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, мэдээллийн бодит байдлыг хангахад шаардагдах төсөв, санхүүгийн тооцоо, судалгааг хийж, эх үүсвэрийг улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

3/үндэсний статистикийн тооллого судалгаа, мэдээний чанар, хамралт анхан шатны нэгжээс шууд хамааралтайг үндэслэн Статистикийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу статистикийн үйл ажиллагааг анхан шатанд эрхлэн гүйцэтгэдэг сумын Засаг даргын Тамгын газрын тухайн асуудал хариуцсан ажилтан, баг, хорооны Засаг даргын ажиллах нөхцөлийг сайжруулах, тэднийг орчин үеийн техник, хэрэгслээр шат дараалалтай хангах зохион байгуулалтын арга хэмжээ авах;

4/Монгол Улсын боловсролын салбарт статистикийн үйл ажиллагааг дэмжсэн бодлого хэрэгжүүлж, статистикийн салбарын мэргэжлийн боловсон хүчнийг сургах, давтан сургаж мэргэшүүлэх тогтолцоог боловсронгуй болгох.

2.Статистикийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд чиглэл болгосугай.

1/Монгол Улсыг хөгжүүлэх дунд болон урт хугацааны бодлого чиглэл, Статистикийн салбарыг 2017-2020 онд хөгжүүлэх хөтөлбөртэй уялдуулан

Статистикийн тухай хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах;

2/төрийн захиргааны төв байгууллагуудын статистикийн мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, төрийн мэдээллийн нэгдмэл сангийн сүлжээг байгуулах;

3/төрийн захиргааны холбогдох байгууллагатай хамтран статистикийн мэдээллийн чанар, үнэн зөв байдалд хяналт шалгалт хийх, шат шатны хариуцлагыг өндөржүүлэх чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах;

4/албан ёсны статистикийн үйл ажиллагааг мэргэжлийн төвлөрсөн удирдлагаар хангаж, мөрдөгдөж байгаа арга зүй, аргачлалд үнэлгээ хийж, тэдгээрийг боловсронгуй болгох арга хэмжээ авах;

5/хөгжлийн төлөвлөлт, төрийн бодлого шийдвэрийн боловсруулалт, удирдлага зохицуулалт, хяналт шалгалтын ажилд шаардлагатай статистик мэдээлэл, судалгааны нэр төрлийг нэмэгдүүлэх, статистикийн судалгаа шинжилгээний чанарын түвшинг дээшлүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан нэгтгэн гаргаж, Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Үндэсний статистикийн хороо /А.Ариунзаяа/-нд үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 04 сарын 26 өдөр Дугаар 09 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.5 дахь хэсэг, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2017 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх чиглэлээр Монголбанкнаас 2017 онд зохион байгуулсан ажлын талаарх Монголбанкны Ерөнхийлөгчийн мэдээллийг Байнгын хороонд сонсох бэлтгэл хангах болон санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн

Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай.

Н.Мөнхзэсэм -Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх

С.Тэгшжаргал -УИХ-ын Тамгын газрын Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Төсвийн шинжилгээний албаны ахлах зөвлөх

Б.Ууганцэцэг -Эдийн засгийн байнгын хорооны Ажлын албаны референт

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 02 өдөр Дугаар 10 Улаанбаатар хот

**Чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, санхүүгийн зах зээлийн хөгжлийг дэмжих хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд чиглэл болгосугай:

1/санхүүгийн салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж, Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл болон Эдийн засгийг сэргээх хөтөлбөрт заасан хууль тогтоомжийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах;

2/хууль тогтоомж боловсруулах, санхүүгийн салбар дахь төрийн үйлчилгээг орон нутагт шуурхай хүргэх ажлыг зохион байгуулах, шаардлагатай төсөв, тооцоог гаргаж, улсын төсөвт тусгуулах;

3/санхүүгийн салбарын хууль тогтоомж болон бодлогын баримт бичгүүдийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооны дунд хугацааны стратеги төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

4/Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, мэдээлэл хүргэх, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг үнэлэх чиглэлээр цогц арга хэмжээг авч, энэ чиглэлээрх Монгол Улсын тогтолцооны үнэлгээг сайжруулахад идэвхтэй дэмжлэг үзүүлэх;

5/2015 оны 7 дугаар сараас өмнө Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээний актуудыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлж шинэчлэн боловсруулж, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад бүртгүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг шуурхай авах;

6/эрсдэлд суурилсан хяналт шалгалтын тогтолцоонд шилжих, хөрөнгийн хүрэлцээт байдал, төлбөрийн чадвар, нөөц санг тооцох аргачлалыг боловсронгуй болгох, өөрийн эрсдэл болон төлбөрийн чадварыг үнэлэх, санхүүгийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоог бүрдүүлэх;

7/блокчейн технологи, криптовалютын талаар олон улсад авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, зохицуулалтын талаар судалж, зохицуулалтын арга хэлбэрийн талаарх саналаа холбогдох байгууллагатай хамтран боловсруулах;

8/гадаадын хөрөнгийн бирж дээр хувьцаа гаргасан Монгол Улсын компаниудын талаарх шаардлагатай мэдээллийг авах чиглэлээр гадаад улсын зохицуулагч байгууллага болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах;

9/хөрөнгө оруулалтын сан, менежментийн компани зэрэг институцийн хөгжлийг дэмжих замаар хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломж, нөхцөлийг сайжруулах;

10/санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;

11/төрийн өмчит аж ахуйн нэгжийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд нээлттэй гаргах, санхүүжилт босгохтой холбоотой үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;

12/иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, хөрөнгийн зах зээлийг сурталчлах ажлыг холбогдох хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу тогтмол зохион байгуулах;

13/Улсын Их Хурлын даргын 2018 оны 60 дугаар захирамжаар байгуулагдан ажилласан шалгалтын ажлын хэсгийн санал, дүгнэлтэд туссан үүрэг, чиглэлүүд болон уг шалгалтын дүн, Санхүүгийн зохицуулах хорооны 2017 оны үйл ажиллагааны тайланг Байнгын хороогоор хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан санал, дүгнэлт, зөвлөмж, анхааруулгыг нэг бүрчлэн судалж, үйл ажиллагааныхаа төлөвлөгөө, бодлого, чиглэлд тусгаж хэрэгжүүлэх.

2. Энэ тогтоолын биелэлт болон Улсын Их Хурлын даргын 2018 оны 60 дугаар захирамжаар байгуулагдан ажилласан шалгалтын ажлын хэсгийн санал, дүгнэлтийн хэрэгжилтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан гаргаж, Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 05 сарын 04 өдөр | Дугаар 12/11 | Улаанбаатар хот

**Хамтарсан ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг."Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030" батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд заагдсан Хүртээмжтэй өсөлт ба нийгмийн тэгш байдлыг хангах зорилгын хүрээнд "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, зохистой хөдөлмөр, хувийн бизнес эрхлэх мэдлэг, ур чадвартай залуу үеийг төлөвшүүлж, ажилгүйдлийн түвшинг бууруулна", Мэдлэгт суурилсан нийгэм ба ур чадвар бүхий Монгол хүн бий болгох зорилгын хүрээнд "Хөгжлийн тэргүүлэх чиглэлүүдэд нийцүүлэн мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог боловсронгуй болгож, төгсөгчдөд мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшүүлнэ", "Шинжлэх ухаан, үйлдвэрлэлийн харилцан уялдааг хангаж, мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлнэ" зорилтууд болон Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн ур чадвар, мэргэшилтэй ажилтны тоог нэмэгдүүлэх замаар хүн амын орлогыг дээшлүүлэн дундаж давхаргын хүрээг нэмэгдүүлж, иргэдийн нийгмийн хамгааллыг сайжруулна", "Шинжлэх ухааны удирдлага, зохион байгуулалтын тогтолцоог олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн боловсронгуй болгож, үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг нэвтрүүлж, мэдлэгт суурилсан инноваци, технологи, үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинжлэх ухааны үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлнэ" зэрэг заалтуудын хэрэгжилттэй танилцах, "Ажилсаг Монгол" хөтөлбөр боловсруулах үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Ё.Баатарбилэг -Улсын Их Хурлын гишүүн
Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Д.Ганболд -Улсын Их Хурлын гишүүн
Д.Гантулга -Улсын Их Хурлын гишүүн
З.Нарантуяа -Улсын Их Хурлын гишүүн
Г.Мөнхцэцэг -Улсын Их Хурлын гишүүн
Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн
Я.Санжмятав -Улсын Их Хурлын гишүүн

18

| | |
|---|---|
| А.Ундраа | -Улсын Их Хурлын гишүүн |
| Н.Учрал | -Улсын Их Хурлын гишүүн |
| Л.Энх-Амгалан | -Улсын Их Хурлын гишүүн |

Хоёр.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Д.Тэрбишдагва/-т даалгасугай.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ё.БААТАРБИЛЭГ

УХА0316

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 05 сарын 09 өдөр Дугаар 12 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

| | |
|---|---|
| Л.Элдэв-Очир | -Улсын Их Хурлын гишүүн |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| Л.Болд | -Улсын Их Хурлын гишүүн |
| Ж.Ганбаатар | -Улсын Их Хурлын гишүүн |
| М.Оюунчимэг | -Улсын Их Хурлын гишүүн |
| Б.Ундармаа | -Улсын Их Хурлын гишүүн |

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Л.Элдэв-Очир/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

Батлав: УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН,
АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ Л.ЭЛДЭВ-ОЧИР

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх багийн бүрэлдэхүүн

| | |
|---|---|
| Г.Батхүрэл (ахлагч) | Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын дарга |

Гишүүд:

| | |
|---|---|
| Б.Лхагвасүрэн | Монголбанкны Дэд Ерөнхийлөгч |
| С.Оюунбилэг | Монгол Улсын Ерөнхий Аудиторын Орлогч |
| А.Ариунзаяа | Үндэсний статистикийн хорооны дарга |
| Б.Баярсайхан | Үндэсний хөгжлийн газрын дарга |
| Д.Баярсайхан | Санхүүгийн зохицуулах хорооны Дэд дарга |
| С.Наранцогт | Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| С.Магнайсүрэн | Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Ж.Бат-Эрдэнэ | Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Г.Нандинжаргал | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Д.Энхбат | Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| З.Мэндсайхан | Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга |
| Ц.Ням-Осор | Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын дарга |
| Л.Батмөнх | Эдийн засгийн байнгын хорооны Ажлын албаны зөвлөх |
| Ж.Ганбаяр | Сангийн яамны Эдийн засгийн бодлогын газрын ахлах мэргэжилтэн |
| Х.Оюунцэцэг | Сангийн яамны Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Б.Уганцэцэг | Эдийн засгийн байнгын хорооны Ажлын албаны референт |

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ АЖЛЫН АЛБА

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 05 сарын 09 өдөр Дугаар 05/13 Улаанбаатар хот

## Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.6 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь заалт, "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын 2 дахь заалтыг тус тус үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас "Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын биелэлт, үр дүнгийн талаарх мэдээллийг хэлэлцсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай:

1/"Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2016 оны 34 дүгээр тогтоолын биелэлт хангагдаагүй арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх;

2/ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц, сургууль, цэцэрлэг, соёл, урлаг, онцгой байдлын алба, эмнэлэг зэрэг олон нийтийн байгууллагын барилгыг тэргүүлэх ач холбогдол, газар хөдлөлтийн бичил мужлалын эрсдэлийн зэрэглэлээр эрэмбэлж, буулган шинээр барих арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлах, тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардлыг 2019 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган шийдвэрлэх, мөн бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байх эрх зүйн орчныг бүрдүүлэх;

3/барилга байгууламжийн хийц, бүтээцийн газар хөдлөлтийн тэсвэрлэлтийг тогтоох, турших, дүгнэлт өгөх, барилгын төлөвлөлт, угсралт, ашиглалтын үе шатны чанар, аюулгүй байдлыг хянах чиглэлээр нэгдсэн лабораторийн сүлжээг нийслэл хот, аймаг бүрд бий болгон ажиллуулах, тэдгээрийг боловсон хүчин, багаж, техник, тоног төхөөрөмжөөр хангах, барилгын материалын сорилт шинжилгээний төв лабораторийн бүтэц, орон тоог баталж, цалин хөлс, холбогдох зардлыг 2019 оноос эхлэн жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээг авах;

4/газар хөдлөлтийн гамшгийн үед нэрвэгдэгсдийг эрэн хайх, аврах тусгай зориулалтын техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн хангалтыг сайжруулах, гамшгийн шуурхай удирдлага, зохицуулалтын үндэсний сүлжээ, гамшгаас хамгаалах олон нийтийн сургалт, дадлагын төв байгуулах зардлыг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлэх;

5/барилгын салбарт мөрдөгдөж байгаа норм, нормативын баримт бичгийг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх талаар арга хэмжээ авах;

6/төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн өнөөгийн тогтолцооны гүйцэтгэгчийг шалгаруулах журамд чанар, аюулгүй байдлын шаардлага, хариуцлага зэрэг шалгуур үзүүлэлтүүдийг тэргүүлэх ач холбогдолд тооцох зарчмыг тусган санал боловсруулж, шийдвэрлүүлэх;

7/ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж, дахин төлөвлөх болон дагуул хот, суурьшлын бүс шинээр байгуулах үйл ажиллагаанд аж ахуйн нэгж, хөрөнгө оруулагчдын оролцоог дэмжих арга механизмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчныг бүрдүүлж, шийдвэрлүүлэх.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

О.СОДБИЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

УХА0316

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 05 сарын 16 өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Т.Аюурсайхан - Улсын Их Хурлын гишүүн

Х.Болорчулуун - Улсын Их Хурлын гишүүн

Ц.Гарамжав - Улсын Их Хурлын гишүүн

М.Оюунчимэг - Улсын Их Хурлын гишүүн

С.Чинзориг - Улсын Их Хурлын гишүүн

Д.Эрдэнэбат - Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Я.Содбаатар/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 05 сарын 16 өдөр　　　　Дугаар 15　　　　Улаанбаатар хот

**Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

З.Нарантуяа　　-Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр　　-Улсын Их Хурлын гишүүн

Ж.Ганбаатар　　-Улсын Их Хурлын гишүүн

Я.Содбаатар　　-Улсын Их Хурлын гишүүн

Д.Тэрбишдагва　　-Улсын Их Хурлын гишүүн

Л.Энх-Амгалан　　-Улсын Их Хурлын гишүүн

Д.Эрдэнэбат　　-Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /З.Нарантуяа/-д даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан тус Байнгын хорооны 2017 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

УХА0316

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА　　　　Д.ДАМБА-ОЧИР

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
# БАЙНГЫН ХОРООНЫ
# ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр    Дугаар 16.    Улаанбаатар хот

**Тогтоолд нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Их Хурлын дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 14 дүгээр тогтоолын 1 дэх хэсэгт заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Б.Жавхланг нэмсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА    Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 05 өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

**Чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд тус тус чиглэл болгосугай:

1/хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг дэмжих замаар ажлын байр болон иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

2/төсөв, мөнгөний бодлогын уялдааг хангаж, Засгийн газар, Монголбанкны хамтын ажиллагааг сайжруулах;

3/БНХАУ-ын Ардын банктай байгуулсан своп хэлэлцээрийн үр дүнд үүссэн өр, зээлийн үлдэгдлийг эдийн засагт дарамт учруулахгүй байдлаар шийдвэрлэх;

4/эдийн засагт учирч болзошгүй хүндрэлээс сэргийлэх зорилгоор Монгол улсын төлбөрийн тэнцлийг сайжруулан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолд заасны дагуу гадаад валют, алтны нөөцийг үндэсний импортын нэг жилийн хэрэгцээний хэмжээнээс багагүй түвшинд байлгах арга хэмжээг авах;

5/“Монголбанканд хийсэн шалгалттай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2017 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг Улсын Их Хуралд танилцуулж, төв банкны засаглал, шийдвэр гаргалтын эрсдэлийг бууруулан хариуцлага, хяналтын тогтолцоог бүрдүүлэх.

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосугай:

1/санхүүгийн салбарын эрсдэлийг бууруулах арга хэмжээний хүрээнд активын удирдлагын мэргэшсэн институцийг бий болгох, валютын зохицуулалтын эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр хуулийн төслүүдийг боловсруулж, хууль санаачлагчид уламжлан, Улсын Их Хурлын 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулах;

2/"Банкны зээлийн хүүг бууруулах зах зээлийн орчныг бүрдүүлэх талаар чиглэл өгөх тухай" Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж уг тогтоолд заасан хугацаанд зээлийн хүүг бууруулах стратегийг тус Байнгын хороонд, хэрэгжилтийг хагас жил тутам Улсын Их Хуралд тус тус танилцуулах;

3/үйл ажиллагааны эрсдэлийг бууруулах, төлбөр тооцооны тасралтгүй найдвартай байдлыг хангах, мөнгөн тэмдэгт, эрдэнэсийн сангийн хадгалалт, хамгаалалт болон ажиллагсдын ажлын байрны орчныг сайжруулах;

4/банкны хяналт, шалгалтыг сайжруулан банкны салбарын санхүүгийн чадавхыг нэмэгдүүлэх арга хэмжээг авах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Д.Дамба-Очир/-нд үүрэг болгосугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 06 сарын 05 өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Банкийг дахин хөрөнгөжүүлэх тухай хуулийн төсөл болон холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Ж.Бат-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
С.Чинзориг -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр Сангийн яам, Монголбанк зэрэг яам, газраас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Жавхлан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
# БАЙНГЫН ХОРООНЫ
# ТОГТООЛ

2018 оны 06 сарын 20 өдөр Дугаар 19 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийг 2018-2020 онд хувьчлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн
Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн
Л.Элдэв-Очир -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, газраас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Жавхлан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 06 сарын 22 өдөр                Дугаар 20                Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Таван толгойн нүүрсний ордын үйл ажиллагааг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Л.Мөнхбаатар -Улсын Их Хурлын гишүүн
З.Нарантуяа -Улсын Их Хурлын гишүүн
Г.Тэмүүлэн -Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, газраас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Баттөмөр/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА                Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

31

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 06 сарын 22 өдөр Дугаар 21 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хөрөнгө оруулалтын банкны тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Л.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Л.Энх-Амгалан/-т даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан тус Байнгын хорооны 2018 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
# БАЙНГЫН ХОРООНЫ
# ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр | Дугаар 22 | Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун -Улсын Их Хурлын гишүүн
Б.Дэлгэрсайхан -Улсын Их Хурлын гишүүн
Я.Содбаатар -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, газраас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Ундармаа/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 06 сарын 26 өдөр Дугаар 23 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.“Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2013 оны 18 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн
Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн
Л.Энх-Амгалан -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, газраас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг /М.Оюунчимэг/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 06 сарын 26 өдөр Дугаар 24 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Валютын зохицуулалтын тухай болон Төв банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Т.Аюурсайхан -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн
Х.Болорчулуун -Улсын Их Хурлын гишүүн
Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, газраас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Т.Аюурсайхан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 07 сарын 03 өдөр Дугаар 12/25 Улаанбаатар хот

## Ажлын хэсэгт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 12/11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг нэмсүгэй.

2.2018 оны 5 дугаар сарын 04-ний өдрийн 12/11 дүгээр тогтоолоор байгуулагдсан Хамтарсан ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс Улсын Их Хурлын гишүүн Дорждугарын Гантулгыг чөлөөлсүгэй.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Ё.БААТАРБИЛЭГ

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 02 өдөр Дугаар 26 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоох болон мөнгө хүүлэлттэй тэмцэх тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Ж.Ганбаатар -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Х.Болорчулуун -Улсын Их Хурлын гишүүн
З.Нарантуяа -Улсын Их Хурлын гишүүн
М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг / Ж.Ганбаатар/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр Дугаар 27 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Валютын зохицуулалтын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Ж.Бат-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн
С.Чинзориг -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Ж.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
# БАЙНГЫН ХОРООНЫ
# ТОГТООЛ

2018 оны 10 сарын 09 өдөр Дугаар 28 Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Хэмжил зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн

Б.Дэлгэрсайхан -Улсын Их Хурлын гишүүн

Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн

Л.Элдэв-Очир -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Д.Тэрбишдагва/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

39

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 16 өдөр Дугаар 29 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Төрөөс мөнгөний бодлогын талаар 2019 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

| | |
|---|---|
| Б.Баттөмөр | -Улсын Их Хурлын гишүүн |

**Гишүүд:**

| | |
|---|---|
| Б.Жавхлан | -Улсын Их Хурлын гишүүн |
| М.Оюунчимэг | -Улсын Их Хурлын гишүүн |
| Б.Ундармаа | -Улсын Их Хурлын гишүүн |
| Д.Эрдэнэбат | -Улсын Их Хурлын гишүүн |

2.Ажлын хэсэгт туслалцаа үзүүлэх мэргэжлийн багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр ажиллуулсугай:

| | |
|---|---|
| Н.Баяртсайхан | -Монголбанкны ерөнхийлөгч |
| С.Даваасүрэн | -Санхүүгийн зохицуулах хорооны дарга |
| А.Ариунзаяа | -Үндэсний статистикийн хорооны дарга |
| Х.Булгантуяа | -Сангийн дэд сайд |

3.Ажлын хэсэгт Монголбанк болон холбогдох яам, агентлаг, байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Баттөмөр/-т зөвшөөрсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

VXA0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 16 өдөр Дугаар 50. Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн өргөн мэдүүлсэн Валютын зохицуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг нарын өргөн мэдүүлсэн Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг нэгтгэн чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Ж.Бат-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Т.Аюурсайхан -Улсын Их Хурлын гишүүн
Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн
Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн
М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн
С.Чинзориг -Улсын Их Хурлын гишүүн
Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, ажиллуулахыг Ажлын хэсэг /Ж.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан тус Байнгын хорооны 2018 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 24, 10 дугаар сарын 09-ний өдрийн 27 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 10 сарын 17 өдөр                Дугаар 31                Улаанбаатар хот

**Ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Валютын ханш, бензин, шатахууны үнийн асуудлаар Засгийн газар, Монголбанканд чиглэл өгөх Байнгын хорооны шийдвэрийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн

М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн

Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн

Д.Эрдэнэбат -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, шийдвэрийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оруулж, хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Б.Жавхлан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА                Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 10 сарын 30 өдөр Дугаар 32 Улаанбаатар хот

**Чиглэл өгөх тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 31 дүгээр тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Валютын ханшийг тогтворжуулах асуудлаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд чиглэл болгосугай:

1/макро эдийн засгийн бодлогын хүрээнд импортыг орлох, экспортыг нэмэгдүүлэх, улсын валютын нөөцийг зохистой дээд түвшинд хүргэх чиглэлээр төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах төлөвлөгөө гаргаж, Эдийн засгийн байнгын хороонд 2018 оны намрын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулах;

2/дотоодын нийт бүтээгдэхүүн, инфляцийн түвшин, гадаад худалдааны болон төлбөрийн тэнцэл, гадаад валютын урсгал зэрэг макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн ерөнхий төлөв, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог тогтмол судлан, улирал тутам дүгнэлт гаргаж, Эдийн засгийн байнгын хороонд танилцуулж байх;

3/гадаад худалдаа, төлбөрийн тэнцлийн асуудал хариуцсан Засгийн газрын одоогийн бүтцийг илүү үр дүнтэй ажиллуулах;

4/гадаад худалдааны тэнцлийг хангаж, гадаад, дотоод худалдааны эрх зүйн орчныг боловсронгуй болгох хүрээнд Худалдааны тухай хуулийн төсөл, холбогдох бусад хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх ажлыг 2019 оны нэгдүгээр улиралд багтаан зохион байгуулах;

5/Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.69 дэх заалтыг хэрэгжүүлэх хүрээнд 2019 онд багтаан дотооддоо алт цэвэршүүлэх үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх.

2.Шатахууны хангамж, чанар, стандарт, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т чиглэл болгосугай:

1/газрын тосны хайгуул, ашиглалтын үйл ажиллагааг эрчимжүүлж, Дорноговь аймгийн нутагт баригдах газрын тос боловсруулах үйлдвэрийн техник,

эдийн засгийн үндэслэлийг Эдийн засгийн байнгын хороонд 2018 оны 12 дугаар сарын 15-ны дотор танилцуулах;

2/газрын тосны зарим төрлийн бэлэн болон завсрын бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах, экологийн ангилал, импортолж байгаа боомтоос хамааруулан автобензин, дизелийн түлшний албан татварыг ялгавартай тогтоох, шатахууны үнийн огцом хэлбэлзлийг онцгой албан татварын хувь хэмжээгээр тухай бүр шуурхай зохицуулах зэрэг асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3/Монгол Улс, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн тогтвортой байдлыг хангах, экологийн өндөр ангилал бүхий чанар, стандартын шаардлагад нийцсэн шатахууны үнийн хөнгөлөлт эдлэх асуудлаар хэлэлцэж тохирох;

4/газрын тосны бүтээгдэхүүний хангамжийн олон талт эх үүсвэртэй байх бодлого баримтлах, Гашуун сухайт-Ганц модны боомтоор шатахуун импортлох ажлыг эхлүүлэх.

3.Тогтоолын хэрэгжилтийг 2019 оны нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 11 сарын 07 өдөр Дугаар 33 Улаанбаатар хот

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Радио долгионы тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Шуудангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд, хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:

**Ажлын хэсгийн ахлагч:**

Б.Жавхлан -Улсын Их Хурлын гишүүн

**Гишүүд:**

Л.Болд -Улсын Их Хурлын гишүүн

Б.Баттөмөр -Улсын Их Хурлын гишүүн

Ж.Бат-Эрдэнэ -Улсын Их Хурлын гишүүн

Б.Ундармаа -Улсын Их Хурлын гишүүн

2.Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа авах чиглэлээр холбогдох яам, агентлаг, бусад байгууллагаас мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж ажиллуулахыг Ажлын хэсэг /Б.Жавхлан/-т даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН**
**БАЙНГЫН ХОРООНЫ**
**ТОГТООЛ**

2018 оны 11 сарын 13 өдөр Дугаар 34 Улаанбаатар хот

## Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг үндэслэн Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

Эдийн засгийн байнгын хорооны 2018 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 30 дугаар тогтоолын 1 дэх хэсэгт заасан ажлын хэсгийн бүрэлдэхүүнд “М.Оюунчимэг -Улсын Их Хурлын гишүүн” гэснийг хасаж, “Д.Тэрбишдагва -Улсын Их Хурлын гишүүн” гэж нэмсүгэй.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР

УХА0316

46

# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 11 сарын 13 өдөр Дугаар 35 Улаанбаатар хот

## Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар чиглэл өгөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ипотекийн зээлийн нөхцөлийг хөнгөвчлөх, зээлийн хөтөлбөрийг олон хувилбарт хэлбэрээр хэрэгжүүлэх бодлого баримталж, зээлийн цар хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Монголбанк, Засгийн газраас банкуудад олгох ипотекийн зээлийн эх үүсвэрийн хүүг нэг хувь хүртэл бууруулах, банкуудын өөрийн эх үүсвэрийг татан оролцуулах, зээлийн санхүүжилтийг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-д чиглэл болгосугай.

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монголбанканд чиглэл болгосугай:

1/ипотекийн зээлийн хөтөлбөрийг Засгийн газарт үе шаттайгаар шилжүүлэх хүртэл уг хөтөлбөрийг санхүүжүүлэх;

2/олон улсын санхүүгийн байгууллагуудтай тохирсон нөхцөлийн дагуу Монголбанкан дахь ипотекийн зээлээр баталгаажсан бондын үндсэн төлбөрийн эргэн төлөлтөөс ипотекийн зээлийг санхүүжүүлэх.

3.Ипотекийн зээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай журам, гэрээнд өөрчлөлт оруулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/, Санхүүгийн зохицуулах хороо /С.Даваасүрэн/-нд чиглэл болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтийн явц байдлыг 2018 оны 12 дугаар сард багтаан Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороонд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монголбанк /Н.Баяртсайхан/-нд даалгасугай.

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Д.ДАМБА-ОЧИР